

МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ САЛБАРТ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ ТҮҮВЭР

Б.Бадрах*, Л.Наранчимэг**, Д.Баттуяа***

Хураангуй: Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 онд үнэлж Монгол Улсыг хяналтад байх орнуудын жагсаалт буюу “саарал жагсаалт”-нд оруулсан нь нийгэм, улс төрд дуулиан шуугиан дагуулаад зогсохгүй эдийн засаг, гадаад харилцаанд эрсдэл үүсгэсэн. Мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр хийгдсэн судалгааны ажил нь мөнгө угаахтай тэмцэх ажлын цар хүрээ, түүний эдийн засаг болон бусад салбарт үзүүлэх нөлөө, мөнгө угаалтын хэмжээ, технологийн хөгжилтэй холбоотойгоор үүсэж болзошгүй мөнгө угаах эрсдэлүүд болон мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх сэдвийн хүрээнд бичигдсэн байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь далд эдийн засгийг бий болгож, авлигын үндэс суурь болохын зэрэгцээ улс орны эдийн засаг, улсын төсөвт сөргөөр нөлөөлдөг байна. Мөнгө угаах гэмт хэрэг нь нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн чиглэлийн мэргэжилтнүүдийн оролцоотойгоор үйлдэгддэг учраас нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн шинжилгээний чиглэлээр мөнгө угаахтай холбоотой судалгааны ажлуудын эрэлт бий болж байна. Энэ чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудын талаар тойм дүгнэлт хийсэн болно. Цаашид энэ төрлийн ажил гүйлгээ компанийн санхүүгийн ажил гүйлгээ, нягтлан бодох бүртгэлд хэрхэн нөлөөлж байгаа талаар судлах болно.

Түлхүүр үгс: мөнгө угаах, сэжигтэй гүйлгээ, эдийн засгийн гэмт хэрэг, санхүүгийн шинжилгээ, ФАТФ

LITERATURE REVIEW OF COMBATING MONEY LAUNDERING IN THE FIELD OF FINANCE

Abstract: FATF is an institution that combats money laundering and imposes financial sanction. Due to the evaluation on level of compliance with FATF recommendation, Mongolia was included to the increased monitoring list also known as a “grey list” in 2019. It not only caused social and political scandals, but also posed risks to economic and foreign relations.

A research paper about combating money laundry will be written about the scope of anti-money laundering activities, its impact to the economy and other sectors, amount of money laundering, potential money laundering risks associated with technological advances and detect money laundering crime.

A crime of money laundering creates hidden economy, becomes the basis of corruption, and impacts the government budget. Since accountants and economic professionals are involved in the money laundering crime, research papers which includes accounting, financing and economic are in demand.

A brief conclusion was made on research papers in this regard. Furthermore, how this kind of transaction impacts companies financial work and accounting will be studied.

Keywords: money laundering, suspicious transaction, economic crime, financial analysis, FATF

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): badrakh_battsengel@yahoo.com

** МУИС, Бизнесийн сургууль, E-mail): lnaraa9191@gmail.com

*** МУИС, Бизнесийн сургууль, E-mail): battuya.d@num.edu.mn

Удиртгал

Мөнгө угаах үйлдэл нь улс орны болоод олон улсын эдийн засагт нөхөж болшгүй хохирол учруулж болзошгүй эрсдэлүүдийн нэг юм. Мөнгө угаахтай холбоотой хохирол нь дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2-5 хувьтай тэнцэж байна гэж Олон улсын валютын сангийн захирал онцлон тэмдэглэжээ (Camdessus, 1998).

20-р зуунд дэлхий нийтээр бэлэн мөнгөнөөс бэлэн бус төлбөр тооцоонд шилжсэн тэр үеэс мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг нуух зорилготой эдийн засгийн харилцааны зохион байгуулалттай хэлбэр үүссэн гэж үздэг бөгөөд 20-р зууны эхэнд америкийн гэмт бүлэглэлүүд дээрэм, биеэ үнэлэлт зохион байгуулах, хар тамхи, зэвсгийн наймаа зэрэг гэмт хэрэг үйлдэж их хэмжээний хууль бус бэлэн мөнгөтэй болсон байна. Тус гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг чөлөөтэй зарцуулахын тулд түүнийг хууль ёсны дагуу олсон эсэхийг батлах шаардлагатай болсон ба гэмт хэрэгтнүүдийн ашиглаж байсан аргуудын нэг нь хууль бусаар олсон бохир мөнгийг хууль ёсны дагуу олсон мөнгөтэй холих байсан юм. Үүний тулд гэмт хэрэгтнүүд өөрсдийн ажиллуулдаг байсан их хэмжээний бэлэн мөнгө эргэлддэг угаалгын газруудыг ашиглаж эхэлсэн.

Америкийн эдийн засагч, мөнгө угаах терроризмтой тэмцэх салбарын зөвлөх Питер Лилли “гэмт үйлдлээс олсон үр шимийг түүний хууль бус үйлдлээс салгах гэсэн одоогийн хийдэг оролдлогыг тухайн үед америкийн гэмт бүлэглэл хийж байсан. Энэ зорилгоор бэлэн мөнгө их эргэлддэг бизнес эхлүүлж, түүндээ хууль бусаар олсон бохир мөнгөө оруулж, хууль ёсны бэлэн мөнгө гарган авдаг. Угаах гэсэн үг нь угаалга, цэвэрлэгээ гэсэн үгтэй ойролцоо утгатай байгаа ч тухайн үед америкийн гэмт бүлэглэлүүд энэ зорилгод үнэхээр угаалгын машин ашиглаж байсан.” хэмээжээ.

Америкийн гэмт бүлэглэлүүд хууль бусаар олсон бэлэн мөнгөө хууль ёсны болгож харагдуулахын тулд автомат угаалгын газруудыг ашиглаж эхэлсэн 1920-оод оноос “Мөнгө угаах” (money laundering) гэсэн хэллэг үүссэн бөгөөд энэ ойлголт нь хууль бус замаар олсон хөрөнгийг хууль ёсны мэт харагдуулах гэсэн утгатай байв. Аажмаар уг үг хэллэг ярианы хэлнээс албан ёсны бичгийн хэлэнд нэвтэрч улс орнуудын эрхзүйн баримт бичигт тусгагдаж эхэлсэн байна.

Олон улсын мөнгө угаахтай тэмцэх чухал хэрэгслийн нэг бол The Financial Action Task Force /FATF/¹ юм. Улс орнуудын хууль эрхзүй, засаг захиргаа, эдийн засаг, санхүүгийн тогтолцоо зэргээс шалтгаалан улс орон бүр харилцан адилгүй байдлаар мөнгө угаахтай тэмцдэг учраас ФАТФ-аас улс орон бүрийн

¹ Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/ нь 1989 онд байгуулагдсан бөгөөд мөнгө угаах үндсэн арга, схемийг судлах, хууль, эрх зүйг сайжруулах замаар тэдгээрээс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр ажилладаг.

мөнгө угаахтай тэмцэхэд хэрэгжүүлэх ерөнхий стандартыг гаргасан.

Мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр бичигдсэн эрдэм шинжилгээ судалгааны ажил төдийлөн хангалттай бус байгаа хэдий ч саяхан илэрсэн Paradise papers, Panama papers, Offshore leaks² зэрэг мэдээлэл ил гарснаар дэлхийн дахинаа мөнгө угаах гэмт хэргийн цар хүрээ, түүний улс орны эдийн засаг, санхүүгийн систем болон компанийн санхүүгийн ажил гүйлгээ, нягтлан бодох бүртгэлд хэрхэн нөлөөлж байгаад анхаарлаа хандуулж байна. Тиймээс манай улсад ч мөн энэ чиглэлээр хийгдсэн судалгааны эрэлт цаашдаа өсөх төлөвтэй байна. Тиймд мөнгө угаах үйл ажиллагаа, түүнтэй холбоотой хийгдсэн судалгааны ажлуудад дүн шинжилгээ хийсэн болно.

Мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр бичигдсэн ажлууд

Мөнгө угаахтай холбоотой нягтлан бодох бүртгэл, санхүүгийн чиглэлийн судалгаануудаас харахад дараах 5 чиглэлээр судалгаа хийгдэж байна.

- Мөнгө угаахтай тэмцэх ажлын цар хүрээ ба түүний нөлөө
- Мөнгө угаах үйлдлийн бусад салбар болон эдийн засагт үзүүлэх нөлөө
- Мөнгө угаах үйлдлийн цар хүрээ /угаагдсан хөрөнгийн хэмжээ/
- Мөнгө угаах шинэ боломжууд
- Мөнгө угаах үйлдлийг илрүүлэх

Дээрх ангилал тус бүрийн судалгааны талаар тоймлон дүгнэв.

Мөнгө угаахтай тэмцэх ажлын цар хүрээ ба түүний үр нөлөө.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, тэдгээртэй хамааралтай эрх зүйн баримт, дүрэм журмын хэрэглээ, ач холбогдол, үнэлгээний талаар судалгааны ажлууд ихээр бичигдэх болсон байна. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх бүтэц болон тус бүтцийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх, эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд үзүүлж байгаа нөлөө нь эрдэмтдийн сонирхлыг татсаар ирсэн. Судалгааны үр дүнгээс харахад мөнгө угаахтай тэмцэх байгууллага, бүтэц, түүний үйл ажиллагаа, үр дүнг үнэлэхтэй холбоотойгоор судалгаа хийгдсэн байна.

НҮБ-аас гаргасан “The United Nations Convention against Transnational Organized Crime”³ конвенцод мөнгө угаах үйлдлийг тухайн эд хөрөнгө нь гэмт

² Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн холбоо /ИСП/-оос олон нийтэд ил болгосон офшор бүсэд бүртгэлтэй компаниудын үйл ажиллагааны талаарх мэдээллийн сан

³ НҮБ-аас 2000 онд гаргасан Палермогийн “Үндэстэн дамнансан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг” конвенц

хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл эрх зүйн үндсэн зөрчлийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх гэж тодорхойлсон байна. Монгол Улсын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуульд мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдлах гэж тодорхойлсон.

Манай улсын хуульд заасан тодорхойлолт нь Палермогийн конвенцод зааснаас “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж авсан, эзэмшсэн, ашигласан” гэснээрээ ялгаатай байна. Өөрөөр хэлбэл гэмт хэргийн замаар олсон мөнгөөрөө үл хөдлөх хөрөнгө, автомашин худалдан авч хэрэглэсэн тохиолдолд манай улсын хуульд зааснаар мөнгө угаах үйлдэлд тооцогдох бол Палермогийн конвенцод зааснаар мөнгө угаах үйлдэлд тооцогдохооргүй байна.

(Buchanan, 2004) мөнгө угаах үйл явцыг гэмт хэргийн замаар олсон хөрөнгө мөнгийг санхүүгийн системд нэвтрүүлэх, байршуулах, түүний дараагаар хөрөнгө мөнгийг эх үүсвэрээс нь гуравдагч этгээд рүү шилжүүлэх буюу нуун далдлах, эцэст нь бэлэн мөнгө гаргаж авах, том дүнтэй худалдан авалт хийх, өөрийн эсвэл өөрийн хамаарал бүхий этгээдийн нэр дээр татан авах буюу буцаан төвлөрүүлэх төвлөрүүлэх гэсэн гурван үе шатаас бүрддэг гэж үзсэн.

Alberto (2016) мөнгө угаах, терроризмтой тэмцэх зорилгоор Испани улсын шинээр баталсан санхүүгийн өмч хөрөнгийн тухай хуулийн үр нөлөөг Франц болон Герман улсын хуулиудтай харьцуулсан байна. Тэрээр уг хууль нь мэдээлэл хадгалах, хувийн мэдээллийг боловсруулах, гуравдагч этгээд зөвшөөрөлгүйгээр мэдээлэлд хандах зэрэг сул талтай гэж үзсэн.

Aurasu, Aspaella нар (2018) Англи болон Малайз улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хуулийг хөрөнгө хураах талаас нь харьцуулан шинжилсэн байна. Эдгээр хоёр улс ижил төстэй хууль эрх зүйн бүтэцтэй байсан ба Англи улсын мөнгө угаах тухай хууль нь хамрах гэмт хэрэг, нотлох арга барилын хувьд Малайзын хуулиас илүү өргөн хүрээтэй байна гэж дүгнэсэн. Гэсэн хэдий ч Norton (2018) Их Британийн Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулийн өөрчлөлтөд “сэжигтэй үйл ажиллагаа” гэсэн тодорхой ойлголт өгч чадаагүйгээс мэдээлэх үүрэг багасаж эрсдэл ихэссэн байна хэмээн шүүмжилсэн.

Jakobi (2018) дэлхийн хэмжээний мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх

бүтцийг аюулгүй байдлын удирдлагын үүднээс авч үзээд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нь аюулгүй байдлын удирдлагын элементүүдийг тодорхой илэрхийлдэг гэж дүгнэсэн. Pol (2018a) дээрх ажлыг өргөжүүлэн судлаад ФАТФ-ын аргачлалууд үр дүнтэй биш гэж дүгнэсэн. Түүнчлэн Pol (2018b) гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг хураасан хэмжээгээр мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг үнэлж байгаа одоогийн үнэлгээний арга барил нь зөв эсэхэд эргэлзсэн.

Barone, Schneider (2018) нар Мөнгө угаахтай тэмцэх үр дүнтэй зохицуулалт нь гэмт бүлэглэлүүдийн мөнгө угаах үйл ажиллагаанд зарцуулагдах зардлын хэмжээг нэмэгдүүлэх учир дээрх зохицуулалт нь мөнгө угаах гэмт хэргийг бууруулах үр дүнтэй арга гэж үзсэн байна.

Мөнгө угаахтай тэмцэх бүтэц, түүний үр нөлөөг тойрсон мэтгэлцээн нь мөнгө угаахтай тэмцэх эрхзүйн орчин хурдацтай өөрчлөгдөхөд хүргэж байна. Тухайлбал, зохицуулалтын цоорхойг арилгахын тулд Европын холбооны Мөнгө угаахтай тэмцэх тав дахь удирдамжид гишүүн орнуудын санхүүгийн мэдээллийн албадын мэдээлэл солилцохтой холбоотой асуудалд өөрчлөлт оруулахаар санал гаргасан байна. (Bozhilova, 2018)

Дээрх судалгааны ажлуудаас үзэхэд олон улсын хэмжээнд мөнгө угаахтай тэмцэх эрхзүйн баримт бичиг мөрдөгдөж, институт ажиллан мөнгө угаахтай тэмцэх бүтэц бүрэлдэн тогтсон байна. Улс орон бүрийн хууль эрхзүй, засаг захиргаа, нийгэм, эдийн засаг, санхүүгийн бүтцийн ялгаатай байдлаас шалтгаалан ФАТФ-аас гаргасан зөвлөмжүүд улс бүхэнд үр дүнтэй байж чадахгүй байгаа ч мөнгө угаах гэмт хэргийг таслан зогсооход дорвитой нөлөө үзүүлдэг байна. Гэмт хэрэгтэнд оногдуулсан ялын хэмжээнээс илүүтэйгээр хураан авч, улсын орлого болгосон хөрөнгийн хэмжээгээр олон улсад мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүнтэй байдлыг үнэлдэг байна. Манай улсын хувьд НҮБ-аас гаргасан конвенцод нэгдэн орсон, ФАТФ-н гишүүн орон болж мөнгө угаахтай тэмцэх бүтцийг үүсгэсэн байна.

Мөнгө угаах үйлдлийн бусад салбар болон эдийн засагт үзүүлэх нөлөө.

Судлаачид Мөнгө угаахтай тэмцэх тогтолцоог шүүмжлэхээс гадна мөнгө угаах гэмт хэргийн бусад салбар болон эдийн засагт үзүүлэх нөлөөнд анхаарлаа хандуулсан байдаг.

Schwarz (2011) нэр бүхий 33 ширхэг офшор бүсүүд бохир мөнгө татах, мөнгө угаах зорилгоор ямар бодлого хэрэгжүүлж, хөнгөлөлт үзүүлдэг талаар судалсан. Тэрээр офшор бүсүүд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн

хууль, журам баталж, мөрдөх тийм ч дуртай бус, олон улсын зүгээс дарамт шахалт үзүүлсэн тохиолдолд мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа мэтээр дүр эсгэдэг гэж үзсэн байна. Түүнчлэн (Slemrod & Wilson, 2009) нарын офшор бүсүүд нь хөрш улсуудын татварын бааз суурийг өөртөө шилжүүлэн авах замаар тэдгээр улсуудыг “шимэгчилж” амьдардаг, (Dharmapala, 2008) татварын таатай нөхцөл үзүүлэх замаар аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудтай татварын хувь хэмжээгээр өрсөлддөг гэсэн үзэл баримтлалуудыг дурдсан байна. Picard, Pieretti (2011) нар хар жагсаалтад оруулах гэх мэт улс төрийн дарамт шахалт офшор бүсэд хэрхэн нөлөөлж болох талаар, офшор бүсүүдийн мөнгө угаахтай тэмцэх дүрэм журмыг хэрэгжүүлэх чадварын талаар судалсан. Хэрвээ үзүүлэх дарамт шахалт хөрөнгө оруулагчийн нэр төрд сөргөөр нөлөөлбөл офшор бүст харьяалагдах банкнууд мөнгө угаахтай тэмцэх дүрэм журмыг мөрдөх боломжтой гэж үзсэн.

Mitchell (1998) хууль бусаар олсон их хэмжээний хөрөнгийг нягтлан бодогч болон бусад мэргэжилтнүүдийн тусламжгүйгээр угаах боломжгүй гэж үзээд нягтлан бодогчдын хууль бус үйл ажиллагаанд хэрхэн оролцож байгаа талаар судалгаа хийсэн. Ravenda (2017) Италийн гэмт бүлгийн бохир мөнгийг угаахад ашигласан нягтлан бодох бүртгэлийн аргын талаар судалсан. Харин Botes, Saadeh (2018) нар ийм төрлийн хууль бус үйлдэлтэй тэмцэхийн тулд эдийн засгийн шинжилгээ хийх шаардлагатай гэж нэмэлтээр дүгнэсэн.

Dowers, Palmreuther (2003), Drayton (2002) нар мөнгө угаалт нь санхүүгийн болон нийгэм эдийн засгийн тогтворгүй байдлыг үүсгэж, авлига хээл хахуулийг өөгшүүлэх замаар эдийн засагт сөргөөр нөлөөлдөг гэж үзсэн байна. Hendriyetty, Grewal (2017) нар мөнгө угаалт нь гэмт хэргийн гаралт болон далд эдийн засгийн хэмжээг ихэсгэж, төсөвт орж ирэх татварын хэмжээг бууруулдаг гэж дүгнэсэн.

П.В.Ревенков, А.Г.Воронин (2012) нар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйлдэл нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал болон олон улсын тогтвортой байдалд аюул занал үзүүлдэг гэж баталсан байна. Тэд энэхүү аюул занал нь шууд байдлаар татварын орлогыг бууруулахын зэрэгцээ үндэсний мөнгөн тэмдэгтийн үнэ болон хүүгийн түвшинд сөргөөр нөлөөлж улсын нэр хүндэд үлэмж хэмжээгээр хохирол учруулдаг гэж үзсэн байна.

Энэ чиглэлээр бичигдсэн судалгааны ажлуудаас дүгнэж үзвэл мөнгө угаах гэмт хэрэг нь тухайн улсын нийгэм, эдийн засаг, санхүүгийн салбарт сөрөг нөлөө үзүүлж, далд эдийн засгийг нэмэгдүүлж, авлигын үндэс суурь болдог байна. Мөнгө угаахад нягтлан бодогч гэх мэт мэргэжлийн хүмүүсийн оролцдог бөгөөд тус гэмт хэргийг илрүүлэхийн тулд санхүүгийн мэдээлэлд дүн шинжилгээ, мөрдлөг хийх шаардлага үүсдэг байна. ФАТФ-н зөвлөмж 30-д заасны дагуу

манай улсын хууль сахиулах байгууллагууд санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй мөрдөгчид ажиллуулаж мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэж байна.

Мөнгө угаах үйлдлийн цар хүрээ.

Мөнгө угаах үйлдлийн цар хүрээг тодорхойлсноор түүний хэр ноцтой болон макро эдийн засагт үзүүлэх нөлөөг үнэлэх боломжтой болно. Walker (1999) угаагдсан мөнгөний хэмжээг тооцоолохын тулд “Walker model of global money laundering” загвар боловсруулсан. Уг загварыг ашиглан өргөн хүрээний нээлттэй мэдээллийн сан дээр үндэслэн Европ болон Хойд Америкт 1999 онд жилд 2.85 тэрбум доллар угаагддаг гэж тооцоолсон.

Unger (2013) угаасан мөнгөний хэмжээг 2 аргаар тодорхойлж болно гэж үзсэн. Үүнд дотоодын нийт бүтээгдэхүүн, гэмт хэргийн замаар олсон хөрөнгийн хэмжээ, төлбөрийн балансын зөрүү гэх мэт үзүүлэлт ашиглан, эсвэл “Walker-Gravity model” гэх мэт эдийн засгийн загвар ашиглан угаагдсан мөнгөний хэмжээг олж болно гэж бичсэн байна. Нөгөө талаас дээрх үнэлгээ нь төөрөгдөлд оруулсан, тодорхой бус гэж Thoumi (2005) зэрэг эрдэмтэд шүүмжилсэн байдаг.

Дэлхий даяар жил бүр угаагдаж буй мөнгөний хэмжээг тодорхойлох чиглэлд судлаачид төрөл бүрийн шинжилгээ хийсэн байна. Шинжилгээний үр дүнгээс харахад их хэмжээний мөнгө угаагдаж байгаа нь тус гэмт хэрэгтэй дорвитой тэмцэх шаардлагатайг харуулж байна.

Мөнгө угаах шинэ боломжууд.

Barone, Schneider (2018) нар кибер угаалт болон электрон автомат төхөөрөмж ашиглан мөнгө угаах аюул занал ихсэж байна гэж дүгнэсэн байна. Dostov, Shust (2014) нар Digicash, Биткойн гэсэн криптовалютыг тэдгээрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аюул занал талаас нь судлаад аюул занал багатай гэж үзсэн. Учир нь криптовалот тодорхой хүрээнд эргэлддэг, ашиглахад тусгайлан сургалт шаардлагатай зэрэг хүндрэл үүсгэдэг. Түүнчлэн криптовалютыг фиат мөнгөнд хувиргах шаардлага гардаг, тэгш бус хуваарилагддаг, ханшийн өндөр хэлбэлзэлтэй учир хүмүүсийн анхаарлыг татахгүй бөгөөд зохицуулах баримт бичиг гаргахын тулд криптовалот тус бүрийг шинж чанараар нь судлах хэрэгтэй гэж дүгнэсэн.

Криптовалот ашиглан мөнгө угаах аюул заналыг бууруулахын тулд зохицуулсан баримт бичиг гаргах шаардлагатай гэсэн саналыг Choo (2015) дэмжсэн байдаг.

Криптовалютын эзэн холбогдогчгүй, гүйлгээг нь мөшгөх боломжгүй байдлыг шийдэхийн тулд Turner, Irwin (2018) нар төрөл бүрийн программын тусламжтайгаар гүйлгээний эзэн холбогдогчийг тогтоохыг оролдсон. “Wireshark”, “blockchain.info” зэрэг программын тусламжтайгаар блок гинжин хэлхээгээр дамжуулан гүйлгээг ямар хаягт хүрч байгааг мөшгөх боломжтой байсан бол тухайн гүйлгээ хүлээн авсан хаягийн эзэн холбогдогчийг тогтоох боломжгүй байсан байна. Туршилтаар 0.00449934 ширхэг биткойны гүйлгээг ямар хаягт хүрч байгааг тогтоосон байна.

Технологи хөгжихийн хэрээр криптовалют болон бусад шинэ технологийг ашиглан мөнгө угаах эрсдэл нэмэгдсэн байна. Иймээс криптовалюттай холбоотой харилцааг зохицуулсан эрхзүйн баримт бичиг шаардлагатай гэсэн дүгнэлтэд дээрх эрдэмтэд хүрсэн байна.

Манай улсын хувьд “Виртуал хөрөнгийн тухай” хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа нь сайшаалтай зүйл юм. Криптовалют ашиглан мөнгө угаах чиглэлд мэргэжлийн эрдэмтэн, судлаач, шинжээчид эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийснээр мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн нэмэгдэнэ гэж үзэж байна.


Мөнгө угаах үйлдлийг илрүүлэх.

Гэмт үйлдэл ихэссэнтэй холбоотойгоор хууль бус үйлдлийг автоматаар илрүүлэх төрөл бүрийн систем бүтээх ажлууд хийгдсэн байна. Ngai (2011) даатгалын залиланг илрүүлэх чиглэлээр өгөгдлийн шинжилгээний аргыг хэрэглэх нь ихэссэн боловч мөнгө угаах гэмт хэрэг, ипотек, үнэт цаасны залиланг илрүүлэх чиглэлд дутагдалтай байна гэж үзсэн.

Zhang (2003) корреляци шинжилгээнд тулгуурласан холбоос судлах арга /Link Discovery based on Correlation Analysis- LDCA/ ашиглан мөнгө угаах гэмт хэрэг мөрдөх явцад цугларсан нотлох баримт, мэдээ, мэдээлэлд шинжилгээ хийж ижил төстэй шинж чанараар нь гэмт бүлэглэлийн гишүүдийг тогтоож болох юм гэсэн санаа дэвшүүлсэн. Ингээд бодитоор үйлдэгдсэн мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах ажлын хүрээнд авагдсан нотлох баримтаас овог нэр, ажлын газрын нэр, гүйлгээ хийсэн огноо, цаг, хаяг, гүйлгээний дүн зэрэг мэдээллийг сонгон авч боловсруулсан. LDCA аргын тусламжтайгаар 332 бичиг баримт, 252 хувь хүний мэдээлэлд шинжилгээ хийж, 7 хувь хүнийг гэмт бүлгийн гишүүд гэж тодорхойлсон нь бодит байдалтай нийцсэн үр дүн үзүүлсэн.

Корреляци шинжилгээнд тулгуурласан холбоос судлах арга /Link Discovery based on Correlation Analysis- LDCA/ нь корреляцийн хэмжүүрийг ашиглаж

хоёр өгөгдлийн элементүүдийн ижил төсөөтэй байдлыг тодорхойлох замаар өгөгдлийн хоорондын холбоог судалдаг байна.



Zdanowicz (2009) худалдааны салбарт хийгдэж байгаа мөнгө угаалтыг илрүүлэх чиглэлд судалгааны хийсэн. Тэрээр бараа таваар нийлүүлэгч улсын зах зээлийн үнэ болон дэлхийн зах зээлийн үнийг АНУ-ын экспорт импортын мэдээтэй харьцуулах замаар мөнгө угаалт хийхэд ашиглаж байж болзошгүй бараа таваар болон улсыг тодорхойлсон. Жишээлбэл нийлүүлэгч улсад зарагдаж байгаа кетчүпний үнэнээс 5 хувиар хямд эсвэл 95 хувиар өндөр үнээр худалдан авалт хийсэн гүйлгээнүүдийг мөнгө угаалт хийх эрсдэлтэй гэж үзсэн.

Unger (2013) үл хөдлөх хөрөнгийн салбарт Zdanowicz (2009)-н дээд дурдсан загварыг ашигласан бол Bidabad (2017) аж ахуйн нэгжийн арилжааны банкаар хийсэн гүйлгээг Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлантай нь харьцуулах замаар мөнгө угаалтыг илрүүлж болох юм гэж үзсэн.

Floris (2020) мөнгө угаалтыг илрүүлэх дараах аргын тухай дурдсан. Дүрэмд суурилсан аргын үед урьдчилан тодорхойлсон дүрмүүдийн үндсэн дээр гүйлгээг шинжилнэ. Жишээлбэл Б улсаас шилжин орж ирж буй 7500 еврогоос дээш дүнтэй бүх гүйлгээг анхаарах шаардлагатай гэж тэмдэглэнэ. Уг тэмдэглэгдсэн гүйлгээг шинжлэх пирамид хэлбэрийн бүтэц бүхий төрөл бүрийн түвшний шинжээчид банк санхүүгийн байгууллагад ажиллана. Анхан шатны шинжээч тэмдэглэгдсэн гүйлгээг хуурамч дохио гэж үзэх эсвэл шинжилгээ хийх шаардлагатай гэж үзэн дараагийн шатны шинжээчид шилжүүлнэ. Эцэст нь хамгийн өндөр түвшний шинжээч Санхүүгийн мэдээллийн албанд уг гүйлгээг мэдээлэх эсэхийг шийднэ. Уг аргын сул тал нь их хэмжээний хуурамч дохио илэрдэг, босго дүн үр дүнтэй байдаггүй, өгөгдлийн боловсруулалт үр дүнтэй байдаггүй болон мөнгө угаалтыг автоматаар танин мэдэх боломжгүй байдал юм. Дүрэмд суурилсан аргаар гүйлгээнд үр дүнтэй шинжилгээ хийхийн тулд тусгай арга хэрэгслүүдийг бүтээсэн байдаг. Тухайлбал хиймэл оюун ухаанд суурилсан Financial Crimes Enforcement Network AI Systems (FAIS) гэх хэрэгсэл нь 336 дүрэм ашиглан гүйлгээг шинжилж ангилдаг байна. Тус

хэрэгсэл нь гүйлгээг ангилах хурдыг нэмэгдүүлдэг хэдий ч гүйлгээг цаашид мөрдөн шалгах, шинжилгээ хийхэд хүний нөөц шаардлагатай хэвээр байна. Анхаарах шаардлагатай гэж үзсэн гүйлгээ бүрийг шинжлэх нь зардал өндөртэй бөгөөд үр дүн багатай юм. Түүнээс гадна зөвхөн тодорхойлсон дүрмийн дагуу гарч ирсэн гүйлгээг шинжлэх бөгөөд технологи хөгжихийн хэрээр мөнгө угаах шинэ схем үүсэж байгаа өнөө үед үр дүн муутай юм.

Мөнгө угаалт хийсэн гүйлгээг тогтмол шинжлэн мөнгө угаалтын шинэ схем илэрсэн тохиолдолд мөнгө угаалтын схемийн жагсаалтад нэмэх замаар мөнгө угаах схемийг баяжуулж байх нь үр дүнтэй юм.

Сэжигтэй гүйлгээг тодорхойлох, хяналт хийх ажлын үр дүнг нэмэгдүүлэхийн тулд сайжруулсан эсвэл шинэ арга хэрэгтэй.

Rule-Based Bayesian Network буюу Дүрэмд суурилсан Байес-н сүлжээ гэх аргыг Пакистаны улсын банкнаас гаргасан журамд үндэслэн Khan, Larik, Rajput, Haider /2013/ нар санал болгосон. Уг арга нь эхлээд хэрэглэгчийн зан төлөвт оноо олгох бөгөөд дараа нь хэрэглэгчийн зан төлөвийн түүхэн хандлагад үндэслэн оноог тооцон зөрүүг гаргадаг. Хэрэглэгчийн зан төлөвийн хэвийн хэмжээнээс их хэмжээний өөрчлөлт үзүүлсэн байвал гүйлгээг сэжигтэй хэмээн тэмдэглэнэ.

Clustering гэх арга нь компьютерын систем /machine learning technique/ гүйлгээнүүдийг ижил төстэй байдлаар нь ангилаад дараагаар нь ангилсан гүйлгээнүүд дундаас хэвийн бус гүйлгээг ялгаж авах арга юм. Энэ нь компьютер өөрөө ангилж ялгах учраас гүйлгээг тэмдэглэх эсвэл дүрэм зохиох шаардлагагүйгээрээ давуу талтай юм.

Social Network Analysis арга нь санхүүгийн гүйлгээ хийгдсэн данс хоорондын харилцаан дээр тулгуурласан, түүнийг шинжлэх арга юм. Энэ талаар Colladon & Remondi (2017) нар бичсэн байдаг. Тэрээр судалгаандаа хууль бус зүйл үйлдэхэд хэд хэдэн этгээдийн хооронд харилцах шаардлага гардаг гэж үзсэн бөгөөд гүйлгээнд оролцогч талуудын газар зүй, гүйлгээ, эдийн засгийн шинж чанараар нь үнэлж хоорондын харьцааг нь шинжилсэн.

Decision Tree арга нь machine learning technique ашиглан 1 үндэстэй, олон салаа мөчиртэй мод хэлбэрийн бүтцээр мэдээллийг ангилж ялгадаг. Liu, Qian, Mao, & Zhu (2011) нар Decision Tree арга ашиглан мөнгө угаах загварыг илрүүлэх аргыг санал болгосон.

Random Forests арга нь Decision Tree аргын өргөтгөсөн хувилбар бөгөөд Breiman (2001) хөгжүүлсэн байна. Тус аргыг хэрэглэх үед хэд хэд мод хэлбэрийн бүтэц үүсгэж мэдээллийг ангилдаг байна. Alvarez Jareno, Badal-Valero, & Pavia (2017) нарын Испани улсын бодит мөнгө угаах хэрэг дээр

хийсэн судалгаагаар энэхүү арга нь илүү үр дүнтэй байсан байна.

Хэрэглэгчийн хяналттай ангилах арга бол Support Vector Machines арга юм. Тус арга нь шугаман бус, төвөгтэй харилцааг боловсруулах чадалтай учраас мөнгө угаах эрсдэлтэй сэжигтэй гүйлгээг илрүүлэх ач тустай юм. Tang & Yin (2005) нар дүрэмд суурилсан аргыг орлож чадах арга гэж баталсан.

Neural Network арга нь хүний тархины хэлбэртэй төстэй бүтцээр ангилах арга юм. Тус арга нь төвөгтэй, шугаман бус харилцааг боловсруулах чадвартай. Lv, Ji, & Zhang (2008) нар энэхүү аргыг мөнгө угаахтай тэмцэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэхэд ашиглавал хуурамч хариу гарах нь багасна гэж үзсэн.

Дүгнэж хэлэхэд, Machine learning techniques ашигласан Decision Tree, Random forests, Support vector machines, Neural Network гэх мэт аргууд нь дүрэмд суурилсан аргаас илүү үр дүн үзүүлж, өдөр бүр хийгдэж байгаа олон тооны гүйлгээнээс сэжигтэй гүйлгээг өндөр нарийвчлалтай ялган таних боломжийг олгох юм.

Монгол Улсын хувьд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан мэдээлэх үүрэгтэй этгэдүүд, голчлон арилжааны банкнууд, тус хуулийн 5-р зүйлд заасны дагуу харилцагчийг танин мэдэх, тус хуулийн 7-р зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээлэл, 7.2 дах хэсэгт заасны дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн гүйлгээ болон гүйлгээ хийх оролдлогын талаарх мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлж байна. Санхүүгийн мэдээллийн албанаас сэжигтэй гүйлгээнд дүн шинжилгээ хийгээд шаардлагатай гэж үзвэл хууль сахиулах байгууллагад шилжүүлдэг байна. Хууль сахиулах байгууллагууд тусгай мэдлэг эзэмшсэн шинжээч-мөрдөгчдийн хийсэн эдийн засгийн шинжилгээнд тулгуурлан, мөрдөн шалгах ажлын ажлын арга хэрэгсэл, техник технологийг ашиглан сэжигтэй гүйлгээний мэдээллийг шалгадаг.

Тухайлбал Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 918 дугаартай шийтгэх тогтоолд дурдсанчлан Монгол Улсын хууль сахиулах байгууллага “Нигери улсын иргэн нь Монгол улсын нэр бүхий 3 иргэнтэй хамтран гадаад улсын компанитай ижил нэртэй компани Монгол Улсад үүсгэн байгуулж цахим хэрэгсэл ашиглан Турк улсын компанийг залиж 2.1 тэрбум төгрөгийн хохирол учруулсан, гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг ашиглан үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл худалдан авах, БНХАУ руу шилжүүлэх замаар мөнгө угаасан” гэх

хэргийг илрүүлэн шалгаж, прокурорын байгууллагад шилжүүлснийг Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2019 онд шийдвэрлэсэн байдаг. Шүүхээс дээрх иргэдэд 6-10 жилийн хорих ял эдлүүлэх, 17 ширхэг автомашин, 7 ширхэг уул уурхайн хүнд даацын тээврийн хэрэгсэл, 2 ширхэг орон сууц, 702.8 сая төгрөгийг хураан авч хохирол барагдуулахаар шийдвэрлэсэн байна.⁴

Арилжааны банкнуудаар өдөр тутам хийгддэг их хэмжээний гүйлгээнээс сэжигтэй гүйлгээг олж илрүүлэн мэдээлэх шаардлага үүсдэг. Өдөр тутам хийгдэж байгаа гүйлгээний тоо хэмжээнээс шалтгаалан сэжигтэй гүйлгээг илрүүлэхэд хүндрэл үүсдэгээс гадна арилжааны банкны ажилтны ур чадвар, хүнээс шалтгаалах хүчин зүйл зэргээс шалтгаалж сэжигтэй гүйлгээг илрүүлэхгүй байх эрсдэлтэй. Гүйлгээ нь дан ганц аж ахуйн нэгжид хамааралтай бус хувь хүн, иргэн гүйлгээ хийдэг нь сэжигтэй гүйлгээ илрүүлэх ажлыг улам хүндрүүлдэг. Гэсэн ч арилжааны банкнууд сэжигтэй гүйлгээнд хяналт тавих ёстой. Хяналт тавихтай холбоотойгоор арилжааны банкнууд комплаенсын зардлаа нэмэгдүүлэхэд хүрдэг бөгөөд хяналт нь үр дүнгүй бол тухайн банк төдийгүй улсын хэмжээний мөнгө угаахтай тэмцэх бүтцэд эрсдэл үүсдэг байна.

Харилцагчийн мөнгө угаахтай холбоотой гүйлгээ хийх эрсдэлийг үнэлсэн, өдөр бүр хийгдэж байгаа гүйлгээн дундаас сэжиг бүхий гүйлгээг ялган харуулах чадвар бүхий автомат систем ашиглах замаар дээрх ажлыг үр дүнтэйгээр, зардал багатайгаар зохион байгуулж болно гэж үзэж байна. Түүнчлэн компанийн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгагдсан мэдээллийг арилжааны банкаар дамжуулан хийгдсэн гүйлгээний мэдээлэлтэй харьцуулах замаар мөнгө угаах, татвараас зайлсхийх эрсдэлийг үнэлсэн загвар боловсруулан ашиглах боломжтой. Гадаад орны эрдэмтдийн энэ чиглэлд хийсэн судалгаа, шинжилгээний ажлыг судлах, өөрийн орны банк санхүү, нийгэм, эдийн засгийн орчинд нутагшуулах, цаашлаад Монгол Улсад тохирсон сэжигтэй гүйлгээг ялган таних автомат систем боловсруулах, бий болгох чиглэлд судалгаа хийх шаардлагатай.

Үүний үр дүнд аж ахуйн нэгжүүдэд мөнгө угаах эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэл өндөр бүхий компанийн үйл ажиллагаанд нягт хяналт, мониторинг хийн, сэжигтэй гүйлгээг ялган таньж мэдсэнээр мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн нэмэгдэнэ гэж үзэж байна.

⁴ Шүүхийн шийдвэрийн цахим сан: https://shuukh.mn/single_case/39520?daterange=2019-01-01%20-%202019-12-12&id=1&court_cat=2&bb=1

Дүгнэлт

АНУ-д 1920-оод оноос гэмт хэргийн бүлэглэлүүд хууль бусаар олсон хөрөнгөө хууль ёсны мэт харагдуулж эхэлснээр мөнгө угаах гэсэн хэллэг, ойлголт үүссэн байна. Олон улсын валютын сангийн тооцооллоор дэлхий даяар дотоодын нийт бүтээгдэхүүний 2-5 хувьтай тэмцэх хэмжээний хөрөнгө жил бүр угаагддаг, мөн мөнгө угаалт нь далд эдийн засгийг өөхшүүлдэг, авлигын үндэс суурь болдог, татварын суурийг багасгадаг зэрэг нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байх тул уг гэмт хэрэгтэй тууштай тэмцэх шаардлагатай. Олон улсын хэмжээнд НҮБ-аас гаргасан Палермогийн конвенц болон Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас гаргасан зөвлөмж дээр суурилан улс орон бүр мөнгө угаахтай тэмцэж байна. Монгол Улсын хувьд ФАТФ-н гишүүн орон бөгөөд түүний зөвлөмжид заасны дагуу мөнгө угаахтай тэмцэх бүтцийг бүрдүүлэн, заагдсан ажлуудыг хийж гүйцэтгэх замаар мөнгө угаахтай тэмцэж байна.

Мөнгө угаах үйлдлийн талаар дараах чиглэлд судалгаа хийгдсэн байна. Үүнд: (а) Мөнгө угаахтай тэмцэх бүтэц ба түүний үр нөлөө: судлаачид Мөнгө угаахтай тэмцэх бүтэц, ФАТФ-н гаргасан зөвлөмжийг шүүмжилсэн ба түүний үр нөлөөнд анхаарлаа хандуулсан; (б) Мөнгө угаах гэмт хэргийн бусад салбар болон эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: мөнгө угаах гэмт хэрэг нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлдэг гэж дүгнэсэн; (в) мөнгө угаах үйлдлийн хүрээ: жил бүр дотоодын нийт бүтээгдэхийн 2-5 хувьтай тэмцэх хэмжээний хөрөнгө угаагддаг гэж дүгнэсэн; (г) мөнгө угаах шинэ боломжууд: технологийн болон хяналтын өөрчлөлтөөс шалтгаалан мөнгө угаах шинэ технологиудыг хөгжихөд түлхэц өгсөн байна; (д) мөнгө угаалтыг илрүүлэх: мөнгө угаалтыг автоматаар илрүүлэх чиглэлээр хэд хэдэн загварууд боловсруулсан байна.

Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд нь нягтлан бодогч, санхүүгийн мэргэжилтнийг ашиглах тохиолдол түгээмэл бөгөөд санхүүгийн системд аливаа мөнгөн хөрөнгө нэвтрэн орохдоо эхлээд нягтлан бодогчд нараар дамждаг байна. Тиймээс ФАТФ-ын Зөвлөмж 22, Мөнгө угаах болон Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.9-т нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нарыг мөнгө угаах зорилгоор хийгдэж байж болзошгүй сэжигтэй гүйлгээ, үйлдлийн талаар мэдээлж байх талаар үүрэгжүүлсэн байдаг. Энэ нь Мөнгө угаахтай тэмцэх нь дан ганц хууль сахиулах байгууллагууд, хууль зүйн салбарын асуудал биш олон салбарын хамтын ажиллагаа, тэр дундаа санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн салбар, нягтлан бодогч, аудитор, санхүүгийн шинжээч нарын анхаарах асуудал мөн гэдгийн илрэл юм.

Монгол Улсын хувьд мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр санхүү, эдийн

засаг, нягтлан бодох бүртгэлийн салбарт хийгдсэн судалгааны ажил харьцангуй бага, цаашид уг гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд судалгаа шинжилгээ хийх шаардлагатай байна. Тухайлбал мөнгө угаасан байж болзошгүй сэжигтэй гүйлгээг автоматаар илрүүлэх, мөнгө угааж болзошгүй эрсдэлийг үнэлэх санхүүгийн загвар боловсруулах, эдийн засгийн шинжилгээ хийх чиглэлд судалгааны ажил үгүйлэгдэж байна.

Ашигласан материал

- [1] Төрболд Э, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх Монгол улсын үйл ажиллагаа: Магистрын зэрэг горилсон судалгааны ажил
- [2] Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан: https://shuukh.mn/single_case/39520?daterange=2019-01-01%20-%202019-12-12&id=1&court_cat=2&bb=1
- [3] Alberto, G. S. (2016), “Spain: financial ownership file and money laundering prevention”, *Journal of Money Laundering Control*, Vol. 19 No. 3, pp. 238-248.
- [4] Alvarez-Jareno, J. A., Badal-Valero, E., & Pavia, J. M. (2017). Using machine learning for financial fraud detection in the accounts of companies investigated for money laundering. *Economics department Universitat Jaume*, 3-21.
- [5] Aurasu, A. and Aspalella, A. R. (2018), “Forfeiture of criminal proceeds under anti-money laundering laws: A comparative analysis between Malaysia and United Kingdom (UK)”, *Journal of Money Laundering Control*, Vol. 21 No. 1, pp. 104-111.
- [6] Barone, R. and Schneider, F. G. (2018), “Shedding Light on Money Laundering. Is It a Damping Wave?”, *SSRN Electronic Journal*.
- [7] Bidabad, B. (2017), “Money laundering detection system (MLD) (a complementary system of Rastin banking)”, *Journal of Money Laundering Control*, Vol. 20 No. 4, pp. 354-366.
- [8] Botes, V. and Saadeh, A. (2018), “Exploring evidence to develop a nomenclature for forensic accounting”, *Pacific Accounting Review*, Vol. 30 No. 2, pp. 135-154.
- [9] Bozhilova, K. (2018), “European Union: European Commission Proposes New Anti-Money Laundering Directives”.
- [10] Breiman, L. (2001). Random forests. *Machine learning*, 5-32.
- [11] Buchanan, B. (2004), “Money laundering—a global obstacle”, *Research in International Business and Finance*, Vol. 18 No. 1, pp.

- 115-127.
- [12] Camdessus, M. (1998), "Money laundering: the importance of international countermeasures", in Plenary Meeting of the Financial Action Task Force on Money Laundering, Paris.
 - [13] Chang, R., Lee, A., Ghoniem, M., Kosara, R., Ribarsky, W., Yang, J., Suma, E., Ziemkiewicz, C., Kern, D. and Sudjianto, A. (2008), "Scalable and Interactive Visual Analysis of Financial Wire Transactions for Fraud Detection", *Information Visualization*, Vol. 7 No. 1, pp. 63-76.
 - [14] Choo, K. K. R. (2015), "Cryptocurrency and Virtual Currency: Corruption and Money Laundering/Terrorism Financing Risks?", *Handbook of Digital Currency*, Academic Press, San Diego, pp. 283-307.
 - [15] Chu, H., Lai, C. C. and Cheng, C. C. (2015), "Tax Havens, Growth, and Welfare", *Journal of Public Economic Theory*, Vol. 17 No. 6, pp. 802-823.
 - [16] Colladon, A. F., & Remondi, E. (2017). Using social network analysis to prevent money laundering. *Expert systems with Applications*, 49-58.
 - [17] David Mathuva, Samuel Kiragu, Dulacha Barako, *Journal of Money Laundering Control*, The determinants of corporate disclosures of anti-money laundering initiatives by Kenyan commercial banks , ISSN: 1368-5201, 2020
 - [18] Dharmapala, D. (2008), What problems and opportunities are created by tax havens? *Oxford Review of Economic Policy*, 24(4), 661–679.
 - [19] Dostov, V. and Shust, P. (2014), "Cryptocurrencies: an unconventional challenge to the AML/CFT regulators?", *Journal of Financial Crime*, Vol. 21 No. 3, pp. 249-263.
 - [20] Dowers, K. and Palmreuther, S. (2003), "Developing an international consensus to combat money laundering and terrorism financing", *Infrastructure and Financial Markets Review*, Vol. 9 No. 1, pp. 1-7.
 - [21] Drayton, F. R. (2002), "Dirty Money, Tax and Banking: Recent Developments Concerning Mutual Legal Assistance and Money Laundering in the Caribbean Region and the Region's Responses", *Journal of Money Laundering Control*, Vol. 5 No. 4, pp. 338-344.
 - [22] Floris, V. (2020), "Detection of money laundering transaction network structures and typologies using machine learning techniques", Master Thesis, Erasmus school of economics
 - [23] Hendriyetty, N. and Grewal, B. S. (2017), "Macroeconomics of money laundering: effects and measurements", *Journal of Financial Crime*, Vol.

- 24 No. 1, pp. 65-81.
- [24] Jakobi, A. P. (2018), "Governing illicit finance in transnational security spaces: the FATF and anti-money laundering", *Crime, Law and Social Change*, Vol. 69 No. 2, pp. 173-190.
- [25] Khan, N. S., Larik, A. S., Rajput, Q., & Haider, S. (2013). A Bayesian approach for suspicious financial activity reporting. *International Journal of Computers and Applications*, 181-187.
- [26] Liu, R., Qian, X.-l., Mao, S., & Zhu, S.-z. (2011). Research on anti-money laundering based on core decision tree algorithm. *Chinese Control and Decision Conference*, 4322- 4325.
- [27] Lv, L.-T., Ji, N., & Zhang, J.-L. (2008). A RBF Neural Network Model for Anti-Money Laundering. *Wavelet Analysis and Pattern Recognition*, 209-215.
- [28] Mitchell, A., Sikka, P. and Willmott, H. (1998a), *The Accountants' Laundromat*, Basildon: Association for Accountancy & Business Affairs.
- [29] Mitchell, A., Sikka, P. and Willmott, H. (1998b), "Sweeping it under the carpet: The role of accountancy firms in moneylaunders", *Accounting, Organizations and Society*, Vol. 23 No. 5, pp. 589-607.
- [30] Ngai, E. W. T., Hu, Y., Wong, Y. H., Chen, Y. and Sun, X. (2011), "The application of data mining techniques in financial fraud detection: A classification framework and an academic review of literature", *Decision Support Systems*, Vol. 50 No. 3, pp. 559-569.
- [31] Norton, S. D. (2018), "Suspicion of money laundering reporting obligations: Auditor compliance, or sceptical failure to engage?", *Critical Perspectives on Accounting*, Vol. 50, pp. 56-66.
- [32] Picard, P. M. and Pieretti, P. (2011), "Bank secrecy, illicit money and offshore financial centers", *Journal of Public Economics*, Vol. 95 No. 7, pp. 942-955.
- [33] Pol, R. (2018a), "Anti-money laundering effectiveness: assessing outcomes or ticking boxes?", *Journal of Money Laundering Control*, Vol. 21 No. 2, pp. 215-230.
- [34] Pol, R. (2018b), "Uncomfortable truths? ML=BS and AML= BS2", *Journal of Financial Crime*, Vol. 25 No. 2, pp. 294-308.
- [35] Ravenda, D., Valencia, M. M., Josep, M. A. and Josep, G. B. (2017), "Accrual management as an indication of money laundering through legally registered Mafia firms in Italy", *Accounting, Auditing & Accountability Journal*, Vol. 31 No. 1, pp. 286-317.
- [36] Schwarz, P. (2011), "Money launderers and tax havens: Two sides of the same coin?", *International Review of Law & Economics*, Vol. 31

- No. 1, pp. 37-47.
- [37] Slemrod, J. (2008). Why is Elvis on Burkina Faso postage stamps? Cross-national evidence on the commercialization of state sovereignty. *Journal of Empirical Legal Studies*, 5, 683–712.
- [38] Tang, J., & Yin, J. (2005). Developing an intelligent data discriminating system of antimoney laundering based on SVM. *Machine Learning and Cybernetics*, 3453-3457.
- [39] Thoumi, F. E. (2005), “The numbers game: let’s all guess the size of the illegal drug industry!”, *Journal of Drug Issues*, Vol. 35 No. 1, pp. 185-200.
- [40] Turner, A. and Irwin, A. S. M. (2018), “Bitcoin transactions: a digital discovery of illicit activity on the blockchain”, *Journal of Financial Crime*, Vol. 25 No. 1, pp. 109-130.
- [41] Unger, B. (2013), “Can Money Laundering Decrease?”, *Public Finance Review*, Vol. 41 No. 5, pp. 658-676.
- [42] Walker, J. (1999), “How Big is Global Money Laundering?”, *Journal of Money Laundering Control*, Vol. 3 No. 1, pp. 25-37.
- [43] Zdanowicz, J. S. (2004a), “Detecting money laundering and terrorist financing via data mining”, *Communications of the ACM*, Vol. 47 No. 5, pp. 53-55.
- [44] Zdanowicz, J. S. (2004b), “U.S. Trade with the World and Al Qaeda Watch List Countries - 2001: An Estimate of Money Moved Out of and Into the U.S. Due to Suspicious Pricing in International Trade”.
- [45] Zdanowicz, J. S. (2009), “Trade-based money laundering and terrorist financing”, *Review of Law and Economics*, Vol. 5 No. 2, pp. 855-878.
- [46] Zhang, Z., Salerno, J. J. and Yu, P. S. (2003), “Applying data mining in investigating money laundering crimes”, in *Proceedings of the ACM SIGKDD International Conference on Knowledge Discovery and Data Mining*, pp. 747-752.
- [47] Ревенков, П.В. Финансовый мониторинг: управление рисками отмывания денег в банках / П.В. Ревенков, А.Б. Дудка, А.Н. Воронин, М.В. Каратаев. - Москва : КноРус, 2012. - 279 с. - ISBN 978-5-406-02164-4.